

## “МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛ, ЗӨВЛӨМЗЭЖ

2024.10.14

Нээлттэй Нийгэм Форум Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлтэй хамтран Монгол Улсын 2025 оны төсвийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан юм. Уг хэлэлцүүлэгт иргэний нийгэм, төрийн захиргааны байгууллагууд, хэвлэл мэдээллийн төлөөлөл оролцлоо.

Хэлэлцүүлэгт Сангийн яамнаас ирэх оны төсвийн төслийн төлөвлөлт, Үндэсний Аудитын газраас төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2025 оны төсвийн төслийн талаар гаргасан дүгнэлтээ танилцуулав. Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрт тусгагдсан төсвийн чиглэлээрх зорилтуудын хэрэгжилт болон хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үе шатанд үүсэж болзошгүй авлига, ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар танилцуулснаас гадна хараат бус судлаачийн зүгээс Монгол Улсын 2025 төсвийн хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн төсөвт өртгийн төлөвлөлтийн байдалд хийсэн дүгнэлтээ танилцуулсан юм.

Хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс 2025 оны төсвийн төлөвлөлт, төсвийн удирдлагын тухайд УИХ, Засгийн газарт хандан дараах анхаарах асуудлыг хөндөж, санал гаргалаа. Үүнд:

### **1. Монгол Улсын 2025 оны төсвийн төлөвлөлтийн тухайд:**

- Монгол Улсын жил бүрийн төсвийг алдагдалгүй байхаар төлөвлөж, баталж байх;
- Хөрөнгө оруулалтын зарим шинэ төслийн эхний жилийн санхүүжилтийг хэт бага байхаар тусгасан байгааг анхаарч, санхүүжилтийн хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлэх;
- 2025 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд 2025 оны төсвийн хуулийг нийцүүлэхийн оронд Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахаар өргөн барьсан нь зохисгүй байгааг анхаарах;
- Төсвийн урсгал зардал нэмэгдэж байгааг анхаарч, зардлыг бууруулах арга хэмжээг авах. Жишээлбэл, төрийн албан хаагчдын тоог бууруулах, цэргийн харьяалалтай дуу бүжгийн чуулгуудын тоог цөөлөх, төрийн байгууллагуудын хэвлэл, мэдээллийн ажилтнуудын тоог бууруулах;

- Төсвийн төслийг өргөн барихаас өмнө улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг батлах.

## **2. Бусад:**

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг ёсчлон дагаж мөрдөхгүйгээр түүнд ойр ойрхон олон удаа өөрчлөлт оруулж байгааг зогсоох;
- Улсын төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаар төрийн Аудитын байгууллагын зүгээс болон судлаачдын зүгээс өгсөн зөвлөмжийг Засгийн газар, Сангийн яам анхааран авч үзэж, хэрэгжүүлэх;
- Засгийн газраас өргөн барьсан хөрөнгө оруулалтын төслийн жагсаалт дээр УИХ-ын зүгээс олон тооны төсөл нэмж батлах явдал сүүлийн жилүүдэд давтагдаж байгаа бөгөөд эдгээр нь төсвийн төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх нь тодорхойгүй байсаар ирсэн муу арга барилыг зогсоох;
- Төрийн Хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 22 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг өндөржүүлж, хуулийн дээрх заалтуудыг Сангийн яам, Төсвийн Ерөнхийлөн Захирагч нар ёсчлон дагаж мөрдөх, хуулийн хэрэгжилтэд УИХ-ын зүгээс хяналт тавих;
- УИХ-ын гишүүн нэгэн зэрэг Монгол Улсын Засгийн газрын гишүүн байх нь гүйцэтгэх засаглалд хууль тогтоох байгууллагын зүгээс тавих хяналтыг сулруулж байгаа тул УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг давхар хашихыг цаашид хориглох;
- Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг тухай бүрт нь тооцож байх;
- Сангийн яамнаас төсвийн мэдээлэл авах талаарх иргэний нийгмийн байгууллагын хүсэлтэд Сангийн яамнаас хурдан шуурхай, тодорхой хариу өгдөг байх;
- Авлигыг бууруулах чиглэлээр Авлигатай тэмцэх газрын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- Уул уурхайн төслүүдээс татварыг бүрэн авах. Жишээлбэл, газрын тосны “Петрочайна дачин тамсаг” компанийн төсөл татвараа төлөхгүй байгаа асуудал дээр Авлигатай тэмцэх газар ажиллах тус тус болно.

## **НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

### **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ**